



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 12 сарын 21 өдөр

Дугаар 20

Улаанбаатар хот

Г Тэтгэвэр авах дундаж хугацааны
илэрхийлэл тогтоох тухай

Г

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсэг. Монгол Улсын Үндэсний статистикийн хорооны 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 01/1091 дүгээр албан бичгээр ирүүлсэн саналыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн дагуу нэрийн дансны аргаар өндөр насны тэтгэвэр бодоход баримтлах тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийлэл ("К")-ийг 2024 онд эмэгтэй даатгуулагчид 22 жил, эрэгтэй даатгуулагчид 15 жилээр тус тус тогтоосугай.

2 Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны 20 дугаар тогтоолын 1 дэх заалтыг "Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуулийн дагуу өндөр насны тэтгэвэр бодоход баримтлах тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийлэл ("К")-ийг 2022-2023 онд эмэгтэй даатгуулагчид 22 жил, эрэгтэй даатгуулагчид 15 жилээр тус тус тогтоосугай" гэж өөрчилсүгэй.

3. Энэ тогтоолоор баталсан тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийллийг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн дагуу нэрийн дансны аргаар өндөр насны тэтгэвэр бодоход баримталж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар /Л.Мөнхзул/-т даалгасугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн Ажлын алба /Г.Банзрагч/-нд үүрэг болгосугай.

5. Энэхүү тогтоолыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

ДАРГА

Х.БУЛГАНТУЯА

